



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/720

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рэнчинлхүмбэ сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны угсралтын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөр 31900,0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төслийн сангаас санхүүжүүлсүгэй.

2. Рэнчинлхүмбэ сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны барилгын угсралтын ажлын зураг, төсөл боловсруулах зөвлөхөөр сонгогдсон "ТЭТҮ" ХХК-тай гэрээ байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Х.Ган-Очир /-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД